



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



## БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН УРИАЛГА

Дэлхийн улс орнууд жил бүрийн 6 дугаар сарын 17-нд НҮБ-аас тунхагласан “Цөлжилттэй тэмцэх олон улсын өдөр”-ийг тохиолдуулан цөлжилтийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, доройтсон газрыг сэргээхэд бүх талын анхаарлыг хандуулж бодитой ажилд уриалж тэмдэглэдэг билээ. 2017 онд цөлжилттэй тэмцэх өдрийг “Бидний газар - бидний гэр, бидний ирээдүй” сэдвийн дор тэмдэглэж байгаа бөгөөд гол зорилго нь хүмүүсийн өдөр тутмын хоол хүнс, амь амьжиргаа газрын өгөөжөөр буй болж байгааг санаж, газар эхээ хайрлах, ариг гамтай, зохистой ашиглах замаар ирээдүйгээ найдвартай байлгахад чиглэсэн бүх талын арга хэмжээг улс орон болгон авч хэрэгжүүлэх явдал юм.

Хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа хөгжлийн тулгамдсан асуудлын нэг нь цөлжилт болоод байгаа бөгөөд дэлхийн эх газрын нийт нутгийн 40 гаруй хувийг эзэлдэг хуурай, гандуу бүс нутаг, тэнд амьдардаг 1,5 тэрбум гаруй хүний амьдралд ихээхэн сөрөг нөлөөтэй юм. Ялангуяа гандуу бүс нутгийн ард иргэдийн амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд ихээхэн эрсдэл үүсгэдэг, эдийн засгийн хор хохирол ихтэй бөгөөд дэлхийн эдийн засагт жилд 42 тэрбум ам.долларийн алдагдал учруулдаг байна.

Өнөөгийн байдлаар, манай орны нутгийн 76.8 хувь нь цөлжилтөд ямар нэг байдлаар өртөөд байна. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн газрын тодорхойлсноор манай орны нийт газар нутгийн 90 орчим хувь нь газрын доройтол, цөлжилтийн аюулд өртөх эмзэг бүс нутагт хамаарагдаж байгаа нь хөгжлийн төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийг энэ эмзэг байдалдаа тохируулан няхуур хийж, доройтлыг үүсгэж байгаа газар ашиглалтын зохисгүй арга хэлбэрийг халж, менежмент, технологийг хөгжүүлэх шаардлагатай болохыг харуулж байна. Монгол орны газарзүйн байршлын онцлог, уур амьсгалын өөрчлөлт зэрэг байгалийн хүчин зүйлээс гадна хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй бэлчээрийн талхагдал, хууль бус мод бэлтгэл, олон салаа зам харгуй, уул уурхайн нөхөн сэргээлт хийхгүй байгаа зэрэг нь цөлжилт тэлэхэд ихээхэн нөлөөлж байна.

Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн газраас дэвшүүлсэн 10 жилийн стратегийн зорилттой уялдуулан Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө шинэчлэн хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийг УИХ-аар батлуулж цөлжилттэй тэмцэх эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгоод байгаа билээ.

Цөлжилтийн аюулыг бууруулах, амьжиргаа, бизнесийн үйл ажиллагааг эрсдэл багатай байлгахад иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага бүрийн бодит оролцоо, хүчин зүтгэл, хувь нэмэр маш чухал учраас мод тарихаас эхлээд бэлчээрээ зохистой ашиглах, нөхөн сэргээлтийг чанартай сайн хийх хүртэл өөрсдийн хийж чадах бүхнээрээ оролцохыг та бүхнээс уриалж байна.

Та бүхний байгалиа хамгаалах буянт үйлс тань улам дэлгэрэн түгэх болтугай.

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Д.ОЮУНХОРОЛ